



ХЭРЭГСЭХГҮЙ БОЛСОН ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, Орхон, Төв аймагт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явагдаж 2018 онд хэрэгсэхгүй болсон эрүүгийн хэргийг судалж, дүн шинжилгээ хийх замаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлд санал зөвлөмж боловсруулах зорилгоор “Төр Иргэн Түншлэл”, “Өнөмөнхийн эгшиглэн”, “Зөв хөгжил, үр дүнт оролцоо” ТББ-уудад Нээлттэй Нийгэм Форум мониторингийн тэтгэлэг олгосон билээ. Эдгээр мониторингийг хэрэгжүүлэхэд хууль зүйн ухааны доктор, дэд профессор Б.Батзориг мэргэжил, арга зүйн удирдамжаар хангаж ажиллалаа. Тус мониторингийг 2019 оны 4-р сараас 12-р сарыг дуусталх хугацаанд хэрэгжүүлэв.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УЕП	Улсын ерөнхий прокурор
ШТГ	Шүүхийн тамгын газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
Эрүүгийн процесс	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д төрөөс хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг тунхагласан байдаг билээ. Төр энэ үүргээ хэрэгжүүлэх нэг баталгаа нь Эрүүгийн хууль тогтоомжоор илэрдэг. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд оршино.¹

¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1. Цахим эх сурвалж: <https://www.legalinfo.mn/law/details/12694?lawid=12694>

Гагцхүү хууль батлагдсанаар хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс хамгаалагдах, тэдгээрийн хөндөгдсөн эрх сэргэнэ гэсэн ойлголт нь өрөөсгөл юм. Тиймээс мөрдөгч, прокурор, шүүх хуулийг чандлан сахих, хууль хэрэглэх хүрээнд хуулийн заалт бүрийг нэг мөр сахих нь гол баталгаа болно. Монгол Улсын эрүүгийн процессын дагуу гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэх асуудлыг шүүхийн хяналтад, харин

эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох ажиллагаа нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналтын шатанд харьяалагддаг. Иймд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуулийг чанд баримталж, хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадаж буй эсэхийг олж тогтоохыг зорилоо.

АРГА ЗҮЙ

Ажиглалтын судалгаа. Шүүх, прокурорын байгууллагуудын мэдээллийн самбар, тухайн шүүх, прокурорын албан ёсны цахим хаягтай танилцаж ажиглалт хийв. УЕП-ын газрын www.prokuror.mn цахим хуудас /орон нутгийн прокурорын байгууллага цахим хуудасгүй/, орон нутаг, салбарын байгууллагын мэдээллийн самбарт 2018 оны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны холбогдолтой мэдээлэл байхгүй байв. Шүүхийн мэдээллийн <http://court.or.gov.mn/shuuh/> цахим хаягаас шүүхийн шийдвэрийг авах боломж бүрдсэн хэдий ч хэрэгсэхгүй болгосон хэргийн материал бүрэн ордоггүй.

Ярилцлагын судалгаа. Шүүх, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч, хохирогч нартай ярилцлага хийж мэдээлэл цуглуулав.

Бичиг баримтын судалгаа. Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг, Орхон, Төв аймгийн

цагдаа, прокурорын байгууллага, шүүхэд хадгалагдаж байгаа хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нийт 10 хэргийн материалыг түүвэрлэн авч судлав.

Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн судалгаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг судлахдаа тус хуулийн төсөл боловсруулах ажилд оролцож байсан судлаачидтай уулзаж үзэл баримтлалын талаар мэдээлэл авсан болно. Эрүүгийн хэргийн материалтай танилцах ажлын хүрээнд УЕП-ын 2011 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн I хавсралтаар баталсан “Эрүүгийн хэргийн төв болон салбар архивд баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, хадгалах, ашиглуулах журам”-тай танилцлаа. Прокурорын байгууллагаас хэргийн материалтай танилцах боломж олгохгүй байсан тул Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийг тусгайлан судаллаа.

МОНИТОРИНГИЙН ЯВЦАД ТУЛГАРСАН БЭРХШЭЭЛ

Мониторингийн мэдээлэл цуглуулах үндсэн арга нь 2018 онд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн материалтай танилцаж дүн шинжилгээ хийх, улмаар хэргийн оролцогчид, хэрэгжүүлэгч нартай уулзахаар төлөвлөсөн байв. УЕП-ын 2011 оны 33 дугаар тушаалаар баталсан “Эрүүгийн хэргийн төв болон

салбар архивд баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, хадгалах, ашиглуулах журам”-ын 5.5-ын б-д зааснаар судалгаа, шинжилгээний чиглэлээр баримттай танилцахаар салбар архивын баримт ашиглуулах эрх, үүрэг бүхий ажилтнуудад албан бичгээр хүсэлт хүргүүлсэн болно. Тус журмын 5.4, 5.6-д тус тус зааснаар

архивын баримт ашиглах зөвшөөрөл олгох эрхтэй боловч УЕП-оос зөвшөөрөл авах ёстой гэсэн нэмэлт шаардлага тавьж байв. Шаардлагын дагуу УЕП-д хандан албан бичиг хүргүүлэхэд Төв аймгийн прокурорын байгууллагад хадгалагдаж байгаа хэргийн материалтай танилцахыг зөвшөөрсөн болно. Харин Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг дэх хэргийн материалтай танилцах боломжгүй тухай УЕП-ын Эрүүгийн хэргийн төв архивын эрхлэгч, хууль цаазын шадар зөвлөх Ж.Чимгээ, Орхон аймагт дахь хэргийн материалтай танилцах боломжгүй тухай тус аймгийн прокурорын газрын тамгын

хэлтсийн дарга Г.Анх-Ирээдүй нараас тус тус албан бичиг ирүүлсэн. Иймд цагдаагийн байгууллагад хадгалагдаж байгаа болон тухайн хэрэг дээр ажиллаж байсан өмгөөлөгчөөр дамжуулан хэргийн материалтай танилцлаа.

Шүүх, прокурорын байгууллагын мэдээллийн самбарт судалгаа шинжилгээний ажилд шаардлагатай хэргийн статистик мэдээлэл байгаагүй. Баянзүрх дүүргийн шүүхийн мэргэжилтэн н.Энхтунгалаг хувь хүний нууцтай холбоотой учир хэрэгсэхгүй болгосон шийдвэртэй танилцуулахгүй гэсэн тайлбарыг өгч байв.

МОНИТОРИНГИЙН ДҮН

Нэг. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.1. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР МЭДЭЭЛЭЛ ХАЙХ, ХҮЛЭЭН АВАХ АЖИЛЛАГААНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл

17/төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 2.20-д хавтаст хэргийг архивд хадгалах прокурорын бүрэн эрхийн эрх зүйн үндсийг тогтоосон. Прокурорын байгууллагын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д зааснаар УЕП-ын газарт эрүүгийн хэргийн төв архив, аймаг, нийслэл, дагнасан прокурорын

газарт түүний салбар архив ажиллахаар хуульчилсан.

Архивд хадгалагдаж байгаа эрүүгийн хавтаст хэргийн материалтай иргэн, хуулийн этгээд танилцах, мэдээлэл авахтай холбоотой дараах эрх зүйн зохицуулалт байна. Үүнд:

1. 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай бол мэдээллийг задруулахыг хориглосон.
2. “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11 дүгээр зүйлд

хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг бүх шатны шүүх, прокурорын байгууллагаас иргэн, хуулийн этгээд авах эрхийг хуульчилсан.

3. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.10, 13.11 дүгээр зүйлд хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан, задруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.
4. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.9 дүгээр зүйлд Мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олж мэдсэн хүн, мөрдөн шалгах ажиллагааны талаар албаны үүргийн дагуу олж мэдсэн алба хаагч, ажилтан прокурорын зөвшөөрөлгүйгээр мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олон нийтэд задруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.
5. УДШ-ийн ерөнхий шүүгч, УЕП-ын хамтарсан 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 36, А/68 захирамж, тушаалаар баталсан “Хавтаст хэргийг

хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам”

6. УЕП-ын 2011 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн I хавсралтаар баталсан “Эрүүгийн хэргийн төв болон салбар архивд баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, хадгалах, ашиглуулах журам”

Хүчин төгөлдөр үйлчилж буй дээрх хууль, эрх зүйн баримт бичгийн заалтаас харахад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байгаа хэргийн материалтай танилцах ажиллагаа хуулиар хязгаарлагдсан. Харин Эрүүгийн хэргийн статистик тоо баримт болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусаж, хянан шийдвэрлэгдэн архивд хадгалагдаж байгаа эрүүгийн хэргийн материалтай иргэн, хуулийн этгээд танилцахыг хориглоогүй. Түүнчлэн УЕП эрүүгийн хэргийн архивд хадгалагдаж байгаа баримттай танилцах журам батлах эрхгүй учир 1998 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр баталсан Архивын тухай хуулиар тухайн харилцааг зохицуулахаар байна.

1.2.ЭРҮҮГИЙН ПРОЦЕССТ ЭРХ АШИГ НЬ ХӨНДӨГДӨН ОРОЛЦОЖ БҮЙ ОРОЛЦОГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

Эрүүгийн процессын өмнөх хуулиуд нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны эрх мэдлийн хуваарилалтыг түлхүү хуульчилж, тэдний үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн хандлагатай явж ирснийг шинэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар өөрчилсөн. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд заасан иргэний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх боломжийг бүрдүүлэх төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үзэл баримтлалд нийцүүлсэн өөрчлөлт билээ.

Мониторингийн явцад оролцогчдын зүгээс шинэ ЭХХШтХ батлагдсанаар камертай уулзалтын өрөөнд мэдүүлэг авч байгаа учир эрүүдэн шүүх асуудал байхгүй болж байгаа, гэмт хэргийн байдал тогтоогдохгүй хүнийг яллагдагчаар татах үндэслэл үүсэхгүй бол “Хэрэг бүртгэлтийн хэргийг хааж” шийдвэрлэж байгаа нь маш зөв болсон гэсэн дүгнэлт хийж байлаа. Мөн хэрэгт холбогдогчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх олон заалт шинээр нэмэгдсэн гэх нааштай хандлага илэрч байна.

1.2.1. Хохирогчийн эрх зүйн байдал

Хэрэгсэхгүй болгосон хэргийн материалтай танилцсан судлаачдын дүгнэлт

1. Хохирогчдын анхны мэдүүлэг тайлбарт “гомдолтой, хохирол нэхэмжилнэ” гэсэн боловч дараагийн мэдүүлгүүдэд “гомдол, саналгүй, нэхэмжлэх зүйлгүй” гэсэн нь анхаарал татаж байлаа.
2. Хохирогчийн мэдүүлэг, тайлбар нь хэрэг шалгах ажиллагааны явцад өөрчлөгдөж, хохиролгүй, шүүх хуралдаанд суухгүй гэж мэдүүлж байна.

Эрүүгийн хавтаст хэрэгт хохирол, гэм хорыг нөхөн төлсөн тодорхой баримт байхгүй байхад дээр дурдсан байдлаар мэдүүлэг өөрчлөгдөхөд, түүнчлэн хохирогчийн эрх зүйн байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг судлахад анхаарал татсан дараах нөхцөл байдлыг судалгаанд оролцогчид тодорхойлон хэлж байв. Үүнд:

- Мөрдөгч хохирогч, гэрчийг нэг удаа дуудаад мэдүүлэг авах боломжтой байтал урьдчилсан бэлтгэлгүйгээс үүдэн хэд хэдэн удаа дуудаж мэдүүлэг авдаг.
- Хохирогч зөрүүтэй мэдүүлэг өгч байгаа нөхцөл байдлыг бүрэн тогтоолгүй хэргийг шүүхэд шилжүүлснээс урьдчилсан хэлэлцүүлгээс хэрэг буцдаг.
- Хохирогчид учирсан бие махбодын хохирлыг бүрэн тогтоодоггүй, учирсан хохирлыг барагдуулах ажиллагаа хийдэггүй зэргээс болж хохирогч залхдаг.
- Хохирогч нь бие болон сэтгэл санааны хохирол хүлээдэг тул түүнийг аль болох бодитой тогтоох, хохирогч нь гаднын нөлөөнд автах, бусдад хууртах, мэдүүлгээсээ буцах зэрэг байдлыг прокурорууд сайтар анхаарч ажиллах нь зүйтэй. Шаардлагатай бол мөрдөн шалгах ажиллагаа явуулахад прокурор байлцах, хохирогчтой биечлэн уулзаж байх хэрэгтэй байна.
- Хэргийг удаан шалгаж сунжруулдаг нь хохирогчийг залхаадаг.
- Хэрэг шалгах ажиллагаа ямар шатанд явж байгааг мэдэгддэггүй. Шалгаж байна л гэдэг.
- Хэрэг бүртгэлтийн шатанд хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай хохирогчид мэдэгддэггүй.
- Хэрэг бүртгэлтийн шатанд хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд хохирогчийг хэргийн материалтай танилцуулдаггүй.
- Хэрэгсэхгүй болгосон шийдвэрт гомдол гаргах боломжгүй.
- Мөрдөн байцаалт дуусаад хэргийн материалтай танилцах боломжгүй маш бага хугацаа өгдөг.
- Хэрэг шүүхээс олноороо буцдаг.
- Хэрэг шүүхээс буцсан тохиолдолд хохирогчийн эрхийг хэрхэн хамгаалах талаар хуулийн зохицуулалт байхгүй.
- Шүүхээс хэргийг прокурорт буцаах, хэргийн зүйлчлэлийг зөвтгөж шийдвэрлэх хуулийн зохицуулалт бүрхэг, зарим заалт зөрчилтэй байгаа нь шүүх нэг талыг барьж, эсвэл мөрдөн шалгах ажиллагаа дутуу явуулсан гэдгийг мэдсээр атал эцэслэн шийдвэрлэх, үндэслэлгүйгээр цагаатгасан юмуу ялласан шийдвэр гаргаж байгаа нь хохирогч болон нийтийн эрх ашиг хохирч, шударга ёс гажуудах, үндсэн хуульд заасан хүний суурь эрх ноцтой зөрчигдөх нөхцөлийг бий болгодог.
- Хөөн хэлэлцэх хугацаагаар хэргийг хэрэгсэхгүй болгож хэрэгтнийг ял завшуулахаас гадна хохирогчийн эрхийг хамгаалдаггүй.
- Хэргийг прокурорын шатанд тухайн хүнийг яллагдагчаар татаж яллах цагаатгах талын бүх баримтыг бүрдүүлж шалгасан боловч тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн нь хангалттай тогтоогдоогүй эсхүл түүнийг яллаж болохгүй бусад үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож, хохирогч хохироод үлддэг.

Судалгаанд хамрагдсан хохирогчийн ярилцлагаас

Биднийг хохироосон хүмүүс давуу эрхтэй байдаг. Хуулиуд нь хохирсон хүмүүсийг биш харин гэмт хэрэгтнүүдийг илүү хамгаалдаг болсон.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн онцлог нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж шүүх тогтоогоогүй тохиолдолд хохирол нөхөн төлөхтэй холбоотой асуудлыг албадлага хэрэглэн төлүүлэхээр зохицуулах боломжгүй. Хэдий тийм ч хохирсон хүн ихэнхдээ хохирол, гэм хороо төлүүлэхийг хүсдэг. Энэ тохиолдолд хохирогчийн хууль ёсны эрх ашгаа хамгаалуулах эрх зүйн байдлыг дордуулсан, боломжийг хязгаарласан дараах хүчин зүйлс байна. Үүнд:

- Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийг харгалзан дэмжих, эд хөрөнгийг хамгаалах асуудал хангалтгүй хийгддэг.
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хохирогч болон түүнтэй холбоотой этгээдийн хувийн нууцыг задруулахгүй байх арга хэмжээг бүрэн авдаггүй.
- Бичиг үсэг мэдэхгүй хохирогч өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх ёстой байтал тэгдэггүй.
- Төлбөрийн чадваргүй яллагдагч, шүүгдэгч үнэгүй өмгөөлөгч авч байхад төлбөрийн чадваргүй болсон, хамаг зүйлээ алдсан хохирогч улсын өмгөөлөгч авч чаддаггүй.
- Хохирогч өмгөөлөгч авч чадахгүй байхад гэмт хэрэгтнүүд олон өмгөөлөгч авдаг.
- Хохирогч өмгөөлөгч авсан хөлсийг нөхөн төлүүлдэггүй. Хохирсон дээрээ нэмж хохирдог.
- Шүүхийн шийдвэр гарчхаад байхад хохирол барагдуулдаггүй.

Судалгаанд оролцогчдын ярилцлагаас

Хэргийг удаан шалгадаг хэрэгт холбогдогч, сэжигтэн, хохирогчийн хувьд зардал ихтэй, тэднийг чирэгдүүлдэг, хүндрэлтэй нөхцөл үүсгэдэг учир залхдаг.

Хэргийн хүнд, хөнгөн, олон холбогдогчтой, хэд хэдэн үйлдэлтэй, үйлдлийн арга нарийн зэрэг хүчин зүйлээс шалтгаалан хэрэг шалгах ажиллагаа удааширдаг. Гэвч хурдан шалгаад шийдэх хэрэг дээр хугацаа алдаж, мөрдөн шалгах ажиллагааг удаашруулахад хүргэдэг нөхцөл байдлыг эрүүгийн хэргийн нөхцөл байдал болон оролцогчдын саналд үндэслэн дараах байдлаар багцлан илэрхийлж болохоор байна. Үүнд:

- Эрүүгийн мөрдөгч хэргээ шалгаад мөрдөгчид шилжүүлдэг. Нэг мөрдөгч 70-100 хэрэг шалгахаар болж ачаалал нэмэгдсэн.
- Нийт гэмт хэргийн 60 хувийг мөрдөн байцаах тасаг, 30 хувийг нь хэрэг бүртгэх тасаг хариуцдаг. Үүнээс болоод эрүүгийн цагдаагийн ачаалал нэмэгдсэн.
- Нэг прокурор өдөрт 20-30 орчим хэрэг хянахаар болж ачаалал нэмэгдсэн.
- Хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд зөвшөөрөл олгох эрхийг прокурорт шилжүүлснээс лавлагаа авахаас эхлээд бүх ажиллагаанд прокуророос зөвшөөрөл авдаг болсон. Энэ нь мөрдөн шалгах ажиллагаанд хугацаа алдах, бие даасан шуурхай ажиллагаа алдагдахад хүргэж, улмаар мөрдөгч нарын эрх мэдлийг хязгаарлаж байна.
- Хэрэг шалгах ажиллагааны хугацааг сунгахад тодорхой хязгаар байдаггүй.
- Лавлагаа, дансны хуулга прокурорын зөвшөөрөлтэй авахаар заасан. Хуучин тасгийн дарга хяналт тавиад авдаг байсан. Үүнээс болж хугацаа алдаж байна.
- Гэрчийг асуухдаа зарим зүйлийг огт асуухгүй орхигдуулах, орхигдсон зүйлийг асуулгах гэж прокуророос, эсвэл шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс буцдаг.

- Оролцогчдын хүсэлтийг тухай бүр нь хүлээн авч шалгаагүйгээс шүүхээс буцаж хугацаа алддаг.
- Мөрдөн шалгах ажиллагаа дутуу хийгддэгээс болж хэрэг шүүхээс буцдаг.
- Мөрдөгч нар хууль зөрчсөн болон буруу хэрэглэснээс болж хэрэг шүүхээс буцдаг.

1.2.2. Яллагдагч, шүүгдэгчийн эрх зүйн байдал

“Нэг хүнийг хэлмэгдүүлснээс мянган хүнийг цагаатга” гэсэн нь хүнийг хилсээр ял шийтгэл оногдуулчихаад дараа нь эрхийг сэргээнэ гэхээс илүүтэйгээр гэм бурууг нь гарцаагүй баримтаар нотол, чадахгүй бол цагаатга гэсэн зарчим юм. Цагаатгана гэдэг нь хэрэг шалгах ажиллагааг бүрэн зогсоох утга агуулдаггүй. Хэрэг бүртгэлтийн ажиллагаа үргэлжлэн явагдах бөгөөд шинэ баримт, нотолгоо илэрч тогтоогдсон тохиолдолд мөрдөн байцаалт дахин эхэлнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас

1.14 дүгээр зүйл. Өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах

1. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн гэж үзэж байгаа хүн, хуулийн этгээд өөрийгөө өмгөөлөх, эсхүл өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй.

2. Хүн, хуулийн этгээд хуульд заасны дагуу хууль зүйн туслалцаа авах, өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх боломж, нөхцөл, цаг хугацаагаар хангагдана.

Монголын эрүүгийн процессын олон жил уламжлагдан ирсэн тогтолцооны гол цөм нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шат юм. Өөрөөр хэлбэл, хэргийг эцэслэн шийдвэрлэхэд ач холбогдолтой бүхий л нотлох баримт, нөхцөл байдал шүүхийн шатанд бус шүүхийн өмнөх шатанд бүрэлддэг. Иймд яллагдагч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгч, прокурорын дотоод итгэл, “нэг тал”-ыг

барьсан нотлох баримтыг өмгөөлөгчийн оролцоотойгоор засах боломжтой.

Өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас

Хэргийн холбогдогч, оролцогч нарт мөрдөгч ямар ажиллагаа хийж байгаагаа огт мэдэгддэггүй. Шалгаж байгаа гээд л явуулаад байдаг. Хийгдсэн ажиллагаанд оролцох хүсэлт гаргахгүй бол оролцуулдаггүй. Хавтаст хэрэгтэй танилцах нөхцөл маш муу, “энэ энэ дээр гарын үсэг зур” гэх байдлаар явагддаг. Учир нь танилцах хугацаа маш бага. Хавтаст хэргийн баримт танилцуулаад гарын үсэг зуруулж болно. Зуруулахгүй байж болно гэдэг. Энэ нь маш сонин зохицуулалт. Танилцуулсан болоод явдаг. Бүх шатанд хэргийн материалтай танилцах боломж олгодог баймаар.

Яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрхийг хангах талаар үүсээд байгаа хүндрэл бэрхшээлийг дурдвал:

- Сүүлийн жилүүдэд төлбөрийн чадваргүй хүмүүс гэмт хэрэгт холбогдох нь нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор өмгөөлөгч нарын хөлс, төлбөр нэмэгдсэн. Төлбөрийн чадваргүй гэсэн ангилалд багтаж чадахгүй болохоор сайн өмгөөлөгч авахад хүндрэлтэй. Өмгөөлөгч авсан ч хөлсийг төлж чаддаггүй.
- Орон нутагт төлбөрийн чадваргүй иргэнд үйлчилгээ үзүүлдэг 1 өмгөөлөгч ажилладаг. Нэг хэрэгт холбогдсон эсрэг сонирхолтой хэд хэдэн төлбөрийн чадваргүй этгээдэд өмгөөлөл хийхэд учир дутагдалтай, хууль зөрчигдөх байдал гарч байна.
- Хэргийн оролцогч, өмгөөлөгчид мөрдөгч ямар ажиллагаа явуулж байгаагаа мэдэгддэггүй. Хийгдсэн ажиллагаанд оролцох хүсэлт гаргахгүй бол оролцуулдаггүй. Үүний улмаас өмгөөлөгч яллагдагчийн эрхийг бүрэн хамгаалах боломж хязгаарлагддаг.
- Бусад оролцогчийн хүсэлтээр хийгдсэн ажиллагаанд өмгөөлөгч оролцох боломжгүй.

- Мөрдөгч хэргийг шалгаж дуусаад прокурорт хүргүүлэхэд бэлэн болсон материалыг хэргийн яллагдагч, түүний өмгөөлөгчид танилцуулдаг. Хэрэг

шалгах явцад танилцуулдаггүй. Хэргийн материалтай танилцах боломжоор хангадаггүй. Мөрдөгч, прокурор өөрийн үзэмжээрээ тэр хугацааг тогтоодог.

1.3.ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

1.3.1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын төлөв байдал

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол цөм нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шат гэж өмнө нь дурдсан. Энэ шатанд бүхий л мөрдөн шалгах ажиллагаа явагддаг. Өмнөх хуулиас давуу тал нь нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах зэрэг шинэ арга хэрэгсэл нэмэгдсэн.

Мөрдөгч нартай хийсэн ярилцлагаас

Мөрдөгч нар бие дааж ажиллах боломж хязгаарлагдсан. Бүх эрх мэдэл прокурорт шилжсэн боловч бүх ажлаа мөрдөгч нараар хийлгэдэг. Зарим прокурорууд хүнд сурталтай, мэдлэг ур чадвар муу.

Прокурортой хийсэн ярилцлагаас

Манай улсад сүүлийн жилүүдэд мөрдөгчтэй холбоотой маш том гажуудал үүсээд байна. Мөрдөгч хэргээ шалгахгүй, хянахгүйгээс хугацаа их алддаг. Өөрийн ажил үүргийн хувиараа зөв төлөвлөж ажиллаагүйгээс үүдэн ямарваа нэг гарсан хэргийн эзэн холбогдогч нь олдохгүй байна гээд түдгэлзүүлчихдэг. Дараа нь гэнэт ажил нь овоорч хугацаандаа амжихгүй болох асуудал үүсэхээр эрэн сурвалжилж байна гээд тогтоол гаргачихдаг. Энэ бол маш том алдаа дутагдал юм. Ингээд тухайн иргэний ажиллаж, амьдарч байгаа болон бусад газарт тус иргэнийг эрэн сурвалжилж байгаа талаар мэдээлэл тархаад явчихдаг. Энэ нь эргээд иргэний нэр хүндэд маш сөргөөр нөлөөлдөг.

Эрүүгийн процессын хуулиар мөрдөгчийн үүрэг хариуцлагыг нарийвчлан зохицуулснаас гадна эрүүгийн хариуцлага өндөр болсон. Тухайлбал, мөрдөгч Эрүүгийн хуулийн 13.4 /хүнийг хүчээр алга болгох/, 13.8 /зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах/, 13.12 /хууль бусаар мөрдөн мөшгөх/, 21.9 /мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах/, 23.6 /хуулиар хориглосон тусгай техник хэрэгсэл ашиглах/, 21.12 /эрүү шүүлт тулгах/, 22.1 /эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/-д заасан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээхээр болсон.

Цөөн үгээр хэлбэл ЭХХШТХ нь мөрдөгч нарын хувьд эрс өөрчлөлт болсон гэж үзэж байна. Үүнтэй холбоотойгоор мониторингийн явцад тогтоогдсон нөхцөл байдлыг багцалбал:

- Хялбаршуулсан журмаар хэрэг шийдвэрлэх ажиллагаа хөнгөн хэрэг дээр хэрэгжээд байна. Харин зарим хүнд гэмт хэрэг дээр хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэдэг болох боломжийг хуульчлах. Тухайлбал хүн амь, залилангийн хэрэг гэх мэт.
- Мөрдөгч болон хяналт тавьсан прокурор тодорхой шалтгаанаар өөрчлөгддөг, энэ нь хэргийн шийдвэрлэлт, хугацаанд нөлөөлдөг нь ажиглагдаж байсан. Тухайн гэмт хэргийн тухайд мөрдөгч болон хэрэгт хяналт тавьж байгаа прокурор шүүхийн шатаар эцэслэн

- шийдвэрлэгдтэл оролцож байх нь ач холбогдолтой.
- Мөрдөгч нар ажил, ачааллаа зөв зохицуулж, төлөвлөдөггүйгээс хэргийн хугацаа алддаг.
 - Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийг шалгахад хүндрэлтэй. Гэмт этгээдийг олж тогтооход нэлээд их цаг хугацаа ордог.
 - Оролцогчдод эрхийг бүрэн тайлбарлаж өгөх явдал хангалтгүйгээс тэд эрхээ зөрчиж байгааг мэдэх боломжгүй байдаг.
 - Мөрдөгчийн даалгавар гэж байсан нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хүчингүй болсон. Мөрдөгчийн даалгаврыг хуульчлах шаардлагатай.
 - Хэрэг бүртгэлтийн шатанд заавал гэрчийн мэдүүлэг авах шаардлага байна уу. Мэдүүлэг авахгүй байхаар зохицуулж болох уу?
 - Мөрдөгч, прокурор хэргийн бодит байдлыг нотлохдоо яллах, цагаатгах бүх баримтыг цуглуулах ёстой. Гэтэл яллах талын баримтыг түлхүү цуглуулах хандлага ажиглагддаг. Хамт байсан ах дүү хүмүүсийн мэдүүлгийг их ач холбогдолтой гэж үздэг. Үүнээс болоод хөндлөнгийн ганц хүн хэрэгт унах тохиолдол практикт байна. Гэрчийн мэдүүлгийг хэргийн байдлыг харгалзан үнэлэх эсэхийг нэг мөр болгох шаардлагатай.
 - Тодорхой эрүүгийн хэрэг нэг бүрд дүн шинжилгээ хийхэд нотлох баримтыг хохирогчийн мэдүүлэгт түшиглэн шалгасан, эсвэл хохирогчийн мэдүүлгийг гүйцэд шалгаж тогтоогоогүй, гэмт хэрэг гарах болсон нөхцөл байдлыг сайтар судлаагүй, мэдүүлгэн нотлох баримт, шууд бус нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажил орхигддог нь судалгааны явцад харагдаж байлаа.
 - Хэргийн газрын үзлэгээр ямар ч ул мөр байхгүй, тэнд байсан нь тогтоогдохгүй байхад гэрчийн худал мэдүүлэгт үндэслэн гэм буруугүй этгээд хохирох эрсдэлтэй байна.
 - Маш олон зөрүүтэй мэдүүлгээс хэргээ хүлээсэн, мөн ганц мэдүүлгээр хэргийг шийддэг. Бусад мэдүүлгийн зөрүүг арилгадаггүй.
 - Шинэчлэн найруулсан ЭХХШТХ 2017 оны 7-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа билээ. Тус хуулийн 9.6 дугаар зүйлийн 6 дахь заалт нь гэрчээр мэдүүлэг өгсөн этгээд эсрэгээр сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болох тохиолдол гарч нэлээд маргаан дагуулж байна. Мөрдөгч нь гэрч биш гэмт хэрэгт сэжиглэгдэх, яллагдагчаар татаж болох этгээд гэдгийг мэдсэн атлаа гэрчээс мэдүүлэг авах, үргэлжлүүлэх нь эсрэгээрээ сэжигтэн, яллагдагчийн эрхийн зөрчил /өөрийн болон гэр бүлийн гишүүдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй, гэм буруутайг болон хэргийн байдлыг нотлох үүрэггүй гэх мэт/-д хүргэж, улмаар хэргийн нотолгооны чадварт, хүчинтэй байдалд сөргөөр нөлөөлөхөөр байна.
 - Яллагдагчид ирсэн өргөдлийг танилцуулахгүй шууд хууль сануулж мэдүүлэг авдаг. Хэрэг бүртгэлтийн ажиллагаа дуусахаар хэрэгтэй танилц гэдэг.
 - Ямар ч хамаагүй хүнийг хамт байсан гэж мэдүүлдэг. Хэргийн байдлыг нотлох үүрэг хүлээхгүй учраас хэдэн ч хүнийг уг хэрэгт хамааруулан мэдүүлэг өгөх боломжтой. Үүнээс нь болж хэрэг шалгахад хугацаа их ордог.
 - Гэрч, хохирогчийг хамгаалах байр байхгүйгээс орон нутагт тэднийг хамгаалах асуудал хүндрэлтэй, эрх нь зөрчигддөг.
 - Сүүлийн жилүүдэд прокурорын байгууллага иргэнд очих мэдэгдлийг бичгээр өгөлгүй цахим сайтдаа тавьдаг болсон. Өмнө нь мэдэгдлийг иргэнд бичгээр албан ёсоор өгдөг байсан бол одоо үгүй болсон гэсэн үг. Хэдий цахим орчныг илүүд үзэж байгаа хэдий ч интернэт орчин хэрэглэдэггүй янз бүрийн түвшний оролцоотой хүмүүс байгаа.

- Мөрдөгч, прокурорууд хэрэгсэхгүй болгосон шийдвэр, бусад шийдвэрийн үндэслэлээ тайлбарладаггүй. Үндэслэл болгосон нотлох баримтаа дурддаггүй. Үүнийгээ дотоод итгэлээрээ шийдсэн гэдэг.
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд оролцогчдын хүсэлтийг үндэслэлгүйгээр хүлээн авахгүй байх тохиолдол гардаг.
- Яллагдагч гадагш явахгүй баталгаа зөрчсөн тохиолдолд шууд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авдаг байх нь зүйтэй. Мөн хоёр буюу түүнээс дээш хөнгөн хэрэг үйлдсэн тохиолдолд шууд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авдаг байх талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгуулах. Энэ нь гэмт этгээд дахин гэмт хэрэг үйлдэх боломжийг хязгаарлаж, иргэд хохирохгүй байх сайн талтай. Хохирогч нарын эрхийг хамгаалж байгаа гэсэн үг.
- Саатуулах байргүйн улмаас өрөөндөө байлгахаас аргагүй. Тус байрнаас яллагдагч оргон зугтах, тэндээс төв рүү аваачих явцад оргосныг оргосонд тооцохгүй байна.
- Яллагдагчийг дуудсан цагт ирэхгүй байгаа нь цагдан хорих үндэслэл болдог байх нь зүйтэй. Цагдан хориогүйгээс болоод хулгайн хэрэгт холбогдсон хүн давтан гэмт хэрэг үйлддэг.
- Гэмт хэргийн шинжгүй буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэх насанд хүрээгүй хүний үйлдлийг шүүхийн шатанд бус прокурорын шатанд хэрэгсэхгүй болгож тогтоол гаргадаг. Прокурорын тогтоолыг яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садны хүнд мэдэгдэхгүй хаах тохиолдол байдаг. Хэргийг хэрэгсэхгүй болгосон бол бүх хүнд мэдэгдэх зохицуулалт оруулах шаардлагатай.

1.3.2. Шүүн таслах ажиллагааны төлөв байдал

Оролцогчийн ярилцлага, хавтаст хэргийн материалаас

1/Шүүхийн шийтгэх тогтоол, шүүх хуралдааны тэмдэглэлээс үзэхэд нийтлэг ажиглагдаж байгаа дутагдал нь ямар үндэслэлээр нотлох баримтыг үнэлсэн, эс үнэлсэн тухайгаа дурддаггүй, прокуророос үйлдэж ирүүлсэн яллах дүгнэлтийн хүрээнд, эсвэл түүнээс хөнгөрүүлэх нөхцөл байдалтай үйлдсэн гэж хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн явдал нэлээдгүй байлаа.

2/... мэдүүлэг зэрэг нотлох баримтаар тогтоогдсон гэж 1443 дугаартай шийтгэх тогтоолд дүгнэн, тэдгээр нотлох баримтыг прокурорын яллах дүгнэлтээс хуулбарлаж бичсэн байна.

Эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа нь нотлох баримт цуглуулж бэхжүүлэх талаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатнаас харьцангуй үүрэг оролцоо багатай. Хэдий тийм ч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хууль, хүний эрх, эрх чөлөө зөрчсөн эсэх гомдлыг эцэслэн шийдвэрлэж зөрчигдсэн эрхийг сэргээдэг. Түүнчлэн хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл болох эсэхийг мэтгэлцээний үндсэн дээр шийдвэрлэдэг. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг эцэслэн тогтоох Монгол Улсын Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхтэй ганц субъект бол шүүх юм.

Шүүх Монгол Улсад шударга ёс, хууль сахин биелүүлэх зарчмыг тогтоон хэрэгжүүлэхэд хэнтэй ч хуваалцахгүй чухал үүрэгтэй. Иймээс эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх явц хуулийн дагуу явах ёстой. Мониторингийн явцад шүүн таслах ажиллагаатай холбоотой тулгамдаж буй зарим асуудлыг дурдвал:

- Шүүхээс зарим хүсэлтийг хангаж зарим хүсэлтийг огт хангахгүй, хүсэлтэд хариу өгөлгүй орхигдуулдаг.
- Шүүх хуралдаан олон удаа хойшилдог.
- Шүүхийн шийдвэрийн гол цөм нь хэргийн үйл баримтыг тогтоосон нотлох баримтуудыг шүүх яагаад үнэн зөв гэж үзэж, шийдвэрийнхээ үндэслэл болгосон талаар бичсэн дүгнэлтийн хэсэг билээ. Гэмт хэргийн талаар шүүхийн тогтоосон үйл баримтыг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжүүдтэй харьцуулан дүгнэж бичих, түүнийг нотолж буй гол нотлох баримтуудын агуулгыг хамтад нь тусгах шаардлагатай.

1.3.3. Шүүх, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч нарын хууль тогтоомжийн тухай ойлголт

Шүүх, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч нар хууль тогтоомжийн талаар нэгдсэн ойлголтгүй гэдгээ бүгд ярилцлагын явцад дурдаж байлаа. Энэ нь ч УЕП-ын 2011 оны 33 дугаар тушаалаар баталсан “Эрүүгийн хэргийн төв болон салбар архивд баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, хадгалах, ашиглуулах журам” прокурорын гурван өөр нэгжид өөр өөрөөр хэрэгжиж байгаагаар баталж болох юм. Түүнчлэн мөрдөгч, прокуроруудын мэдлэг ур чадварыг сайжруулах шаардлагатай байна.

МОНИТОРИНГИЙН ДҮГНЭЛТ

Ерөнхий дүгнэлт

- Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох ажиллагаа нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт, шүүхийн шатанд хэрэгждэг. Хэрэг бүртгэлтийн шатанд хэрэгсэхгүй болгосон шийдвэр гаргах ажиллагаа, оролцогчийн эрх ашгаа хамгаалуулах боломж нь бусад шатнаас харьцангуй хязгаарлагдмал, эрх зүйн зохицуулалт нь ч хангалтгүй байна.
- Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэртэй танилцах, хэрэгсэхгүй болгосон хэргийн материалтай танилцах ажиллагааны хуулиар зохицуулсан ил тод байдал хангалтгүй байна.
- Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох явц дахь хохирогчийн эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон эрүүгийн хууль тогтоомж бүрэн хэрэгжихгүй байна.

Иргэн, хуулийн этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах ажиллагааны нөхцөл байдлын талаар:

- Иргэн, хуулийн этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт бүрдсэн байна.
- УЕП эрүүгийн хэргийн архивд хадгалагдаж байгаа баримттай танилцах журам батлах эрхгүй учир 1998 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр баталсан Архивын тухай хуулиар тухайн харилцааг зохицуулахаар байна. Тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.8-д зааснаар “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд холбогдох баримтын архивын ажлын зааврыг Улсын Ерөнхий прокурор, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, архивын асуудал эрхэлсэн Засгийн

газрын гишүүнтэй хамтран батлахаас зохицуулсан байна.

- Иргэн, хуулийн этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах ажиллагааг зохицуулсан журмыг хэрэгжүүлэх эсэх хувь хүний субъектив хүчин зүйлээс хамаарч байна.

Оролцогчийн эрх зүйн байдлын талаар:

- Хэрэг бүртгэлтийн шатанд мэдүүлэг авах ажиллагааг ихээр явуулж байгаа нь тухайн хэрэг шалгах ажиллагааны нууцлал хамгаалал хангалтгүй болж, улмаар сонирхогч этгээдүүд өөрийн эрх, ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор хэрэг шалгах ажиллагааны талаар мэдээлэл авах сонирхол их болж байна.
- Хэрэг бүртгэлтийн шатанд хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай хохирогчид мэдэгдэх, хэрэгсэхгүй болгосон хэрэгт гомдол гаргах эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.
- Мөрдөн байцаалт дуусаж хавтаст хэргийн материалтай яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч танилцах хангалттай хугацаатай байх зарчим хангагдахгүй байна.
- Эрүүгийн хэрэг шүүхээс олноороо буцаж байгаа бөгөөд эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус байна. Үүнээс улбаалан хэрэг хөөн хэлэлцэх хугацаагаар хэрэгсэхгүй болж, оролцогчийн эрх ашиг хамгаалагдахгүй үлдэх нөхцөл байдал үүсээд байна. Энэ нь хохирогч хохирол, нөхөн төлбөрөө шүүхээр төлүүлэх шийдвэр гаргуулах, хууль бус үйл ажиллагаа явуулсан албан хаагчдад хариуцлага тооцох боломжийг алдагдуулж байгаа нь шударга ёсны тогтолцоонд итгэх олон нийтийн итгэлд сөргөөр нөлөөлж байна.
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хохирогч болон түүнтэй холбоотой этгээдийн хувийн

нууцыг задруулахгүй байх, тэдгээрийн аюулгүй байдлыг хамгаалах зохион байгуулалтын арга хэмжээ сул байна.

- Шударга байдал, тэгш эрхийн зарчимд нийцүүлэн үзвэл хохирогч өмгөөлөгч авч эрхээ хамгаалуулах шаардлага тулгарч байна. Хэрэв мөрдөгч, прокурор хуульд заасан чиг үүргээ хангалттай хэрэгжүүлбэл хохирогч өмгөөлөгч авч эрх ашгаа хамгаалуулах хандлага гарах нь багасна.
- Шүүхийн шийдвэр гарчхаад байхад хохирол барагдуулах ажиллагаа хангалтгүй байна.
- Орон нутагт төлбөрийн чадваргүй иргэнд үйлчилгээ үзүүлдэг 1 өмгөөлөгч ажилладаг. Нэг хэрэгт холбогдсон эсрэг сонирхолтой хэд хэдэн төлбөрийн чадваргүй этгээдэд өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрх нь зөрчигдөх эрсдэлтэй.
- Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийн хүрэлцээ хангалтгүй байна. Энэ нь яллагдагч хууль ёсны эрх ашиг, сонирхлоо хамгаалж чадахгүй байдалд хүрч болзошгүй.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хүнд суртал, ажлын ачаалал нэмэгдэж байгаа талаар:

- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт, шүүн таслах ажиллагаанд ажлын ачаалал бодитоор бий болсон. Энэ нь ихэвчлэн ажлын удирдлага, зохион байгуулалтаас хамааралтай байна.
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгч, прокурорын хуульд заасан ажил үүргийг хуваарилалт тэгш бус, эсхүл энэхүү зохицуулалтын уялдаа холбоо бүрэн бус байна.
- Мөрдөгч, прокурорын мэргэжлийн ур чадвар нь ажлын ачаалал, хүнд суртал бий болгож байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын төлөв байдал

- Өмнөх ЭБШ хуулийн тогтолцоотой адил мэдүүлэгт тулгуурласан нотлох ажиллагаа явагдсаар байна. Ийм учраас бусад нотлох баримтаас мэдүүлгэн нотлох баримтад илүү ач холбогдол өгсөөр байгаа нь хэрэг шалгах ажиллагаа удаашрах, хэрэг шүүхээс буцах зэрэг нөхцөл байдал бий болгож байх талтай.
- Гэрч, хохирогчоос мэдүүлэг авах ажиллагаа нь ЭХХШтХ-иар маш сайн бэлтгэлтэй цөөн удаа хийгдэж байхаар зохицуулсан ч энэ арга барилд прокурор, мөрдөгчид бүрэн суралцаагүй, хангалттай мэдлэггүй байна.
- Мөрдөгч нар ЭХХШтХ-д заасан эрүүгийн процессын нөөц бололцоог бүрэн ашиглахгүй байна. Энэ байдал нь мөрдөгч, прокурорууд үйл ажиллагааны алдаа доголдлыг бие бие рүүгээ, эсвэл хуульд нялзаахад хүргэж байх талтай.
- Мөрдөгч, прокурорууд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх сонирхол нэмэгдэж байна. Энэ нь бүрэн хэрэгжвэл ажлын ачаалал багасах боломжтой. Иймд хуульд зарим зохицуулалтын шинжтэй өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

- Мөрдөгч, прокурор тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нь хэрэг шалгах ажиллагаанд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.
- Эзэн холбогдогчгүй хэрэг шалгах ажиллагааны арга барил нь мөрдөгч нарын ачааллыг нэмэгдүүлж байна.
- Шүүх, прокурор, мөрдөгч нар эрүүгийн хууль тогтоомжийн талаар нэгдсэн ойлголт хангалтгүй, мэдлэг ур чадвар дутмаг байна.
- Хувийн батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээний төрөл шаардлагатай гэж мөрдөгч, прокурор үзэж байна.

Шүүн таслах ажиллагааны төлөв байдал

- Шүүхийн шатанд эрүүгийн хууль тогтоомжийн талаарх нэгдсэн ойлголт хангалтгүй байна.
- Шүүх шийдвэрийнхээ үндэслэлийг тодорхой, нотлох баримтад үндэслэн гаргах, нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл яагаад болоогүй талаар, эсхүл яагаад тухайн нотлох баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болж байгаа тухай шийдвэртээ тусгадаггүй нь оролцогчид шүүгч, шүүхийн шийдвэрийг өөрийнхөөрөө ойлгон тайлбарлахад нөлөөлж байна.

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр:

- Иргэн, хуулийн этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах ажиллагааг зохицуулсан журмыг Архивын хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэр тухай хуулиудад тус тус нийцүүлэн шинэчилж боловсруулах
- Эрүүгийн хэргийн хөөн хэлэлцэх хугацааг ойлгомжтой хуульчлах
- Эзэн холбогдогчгүй хэрэгт хийх мөрдөн шалгах ажиллагааны стандарт буюу аргачилсан журмыг боловсруулах эрхийг хуулиар олгох
- Мөрдөгч, прокурор, шүүгч нь оролцогчийн гаргасан санал, хүсэлтийг хүлээж аваагүй, өмнө авсан шийдвэрээ хүчингүй болгож байгаа тохиолдолд тодорхой үндэслэл бүхий тайлбарыг хүргүүлж, энэ талаар хавтаст хэрэгт тусгадаг байх гэсэн заалтыг хуульд нарийвчлан зохицуулах
- Хэрэг бүртгэлтийн хэргийг хэрэгсэхгүй болгохдоо хохирогчид танилцуулдаг зохицуулалтыг хуульчлах
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд хүндрэл учруулж байгаа зохицуулалтад өөрчлөлт оруулах
- Мөрдөн байцаалт дуусгаж хавтаст хэргийн материал танилцуулах ажиллагааг оролцогчдын өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийн талаарх олон улсын хэм хэмжээнд нийцсэн байдлаар хуульчлах
- Шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа эрүүгийн хэргийг шүүхээс буцаадаггүй тогтолцоонд шилжих байдлаар хуульчлах

- Шүүх шийдвэрийнхээ үндэслэлийг тодорхой, нотлох баримтад үндэслэн гаргах, нотлох баримтыг шүүхийн шийдвэрийн үндэслэл яагаад болоогүй, эсхүл яагаад тухайн нотлох баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болж байгааг шийдвэртээ тусгадаг байхаар хуулиар нарийвчлан зохицуулах
- Мөрдөгч, прокурор, шүүгч оролцогчийн гаргасан санал, хүсэлтийг хүлээж аваагүй, өмнө авсан шийдвэрээ хүчингүй болгож байгаа тохиолдолд тодорхой үндэслэл бүхий тайлбарыг хүргүүлж, энэ талаар хавтаст хэрэгт тусгадаг байх гэсэн заалтыг дэлгэрүүлж оруулах
- Мөрдөгч, прокурор, шүүгч, өмгөөлөгч нар Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг өөр өөрийнхөөрөө тайлбарладаг болсон. Тухайн хуульд шинээр хуульчлагдсан заалтыг хэрэгжүүлэхэд учирч буй хүндрэлийг багасгахын тулд Улсын дээд шүүх хууль тайлбарлах эрх зүйн үндсийг салбар хууль тогтоомжоор зохицуулах.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн судалгааг иж бүрнээр хийх
- Шинээр батлагдсан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжийн хүрээнд мөрдөгч, прокурорын ажлын ачаалал, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах чиглэлээр иж бүрэн судалгаа хийж, оновчтой арга замыг тодорхойлж хэрэгжүүлэх /шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага/
- Мөрдөгч, прокурорыг тогтвортой ажиллуулах нөхцөл бололцоог бүрдүүлж ажиллах /прокурор, цагдаагийн байгууллага /

- Мэдүүлэг авах, мэдүүлгээс бусад мөрдөн шалгах ажиллагааны арга барилыг шинээр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлалд нийцүүлсэн сургалт зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх /шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага/
- Шинээр батлагдсан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, эрдэмтэн судлаачдыг чадавхжуулах ажлыг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хийх ажлыг эрчимжүүлэх /шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага/
- Оролцогчийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагч, сэжигтэн, яллагдагчийн эрхийг энгийн ойлгомжтой байдлаар үзүүлсэн зурагт хуудас байрлуулах.

Зөвлөмжийн үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэх ажилд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлдэг Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хуульчдын холбоо хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллах, эсхүл тус чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагад хариуцуулах
- Дурдсан ажлын хэсэг /хариуцсан иргэний нийгмийн байгууллага/ анхан, дунд, дээд шатанд хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулж, ойлголтыг нэгтгэх, сургалтын хэрэгцээг тодорхойлон мэдээллээр хангах, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох байгууллагад уламжлах
- Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих, иргэдэд тус хуулийг сурталчлан таниулах иргэний нийгмийн байгууллагуудыг чадавхжуулах.



МОНИТОРИНГИЙН ХҮРЭЭНД МЭДЭЭЛЭЛ АВАХ ЗОРИЛГООР ХОЛБОГДОХ АЛБАН БАЙГУУЛЛАГУУДАД ИЛГЭЭСЭН АЛБАН БИЧГҮҮД

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР
ЭРҮГИЙН ХЭРГИЙН ТӨВ АРХИВ
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Баян толгой 15/1.
Утас: 7011 1997, 32 49 84, И-мэйл: ehta@prokuror.mn


№ 09.30 № 1246
Танай _____-ны № _____-т

ЗӨВ ХӨГЖИЛ, ҮР ДҮНТ ОРОЛЦОО ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.МӨНХЖАРГАЛ ТАНАА

Танай байгууллагаас Улсын Ерөнхий Прокурорын газарт гаргасан 2018 оны Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт хэрэгсэхгүй болсон эрүүгийн хэргийн материалыг хийх төслийн хүрээнд хэргийн материалыг танилцах гэсэн хүсэлтийг хүлээн авч танилцлаа.

Улсын Ерөнхий Прокурорын 2011 оны 33 тоот тушаалаар батлагдсан Эрүүгийн хэргийн төв болон салбар архивт баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, хадгалах ашиглуулах журмын 5.14-т зааснаар, баримтыг ашиглуулахдаа зөвхөн тухайн хэргийн оролцогч, тэдгээрийн өмгөөлөгч, хуулийн этгээдийг төлөөлж ирсэн этгээдэд танилцуулахаар зохицуулсан заалттай. Иймд хэрэгсэхгүй болсон хэргийг танилцуулах судалгаа хийлгэх боломжгүй гэж үзлээ.

ЭРХЛЭГЧ, ХУУЛЬ ЦААЗЫН ШАДАР
ЗӨВЛӨХ ЖЧИМГЭЭ



002911

ЗӨВ ХӨГЖИЛ, ҮР ДҮНТ ОРОЛЦОО ТББ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Т.в.ср.д. утас: 42, ЮНЕСКО урлагийн ЮНЕСКО БОСДИГ 13 дугаар 13/07
Телеф: 997744, мэйл: zovhogjil@tbb.mn

2019-09 090919 Улаанбаатар хот

БАЯНЗҮРХ ДҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАРТ


Хүсэлт гаргах нь

"Зөв хөгжил, үр дүнт оролцоо" ТББ-н Нээлттэй Нийгэм Форумас зарласан "Хөгжилтэй" хөдөлгөөн 2018 онд Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт хэрэгсэхгүй болсон эрүүгийн хэргийн материалыг хийх төслийг хэрэгжүүлж байгаа юм.

Уг төслийн зорилго нь 2018 онд шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргээс хэрэгсэхгүй болсон хэргийн мэдээлэл, судалгааг гарган, хэрэгсэхгүй болсон шалтгаан нь юу байсанг дүн шинжилгээ хийж, санал зөвлөмж дүүртэй бүхий тайлан гаргахад оршино.

Тиймээс судалгаа дүн шинжилгээний ажлын зорилгоор мэдээлэл авах, хэрэгсэхгүй болсон хэргийн материалыг танилцах боломжоор хангаж хуваах байна. Төслийн багийн гишүүн болон тус байгууллагын гүйцэтгэл зориулалттай болсон Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт төрийн эрхийн Алтангэрэл нар арвин материалыг танилцах болно. Судалгааны зорилготой ашиглах тул хувь хүн, байгууллагын мэдээллийг заруулахгүй, нууцлалыг хадгалах болно.

Хүндэтгэсэн: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б. МӨНХЖАРГАЛ



ЗӨВ ХӨГЖИЛ, ҮР ДҮНТ ОРОЛЦОО ТББ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Т.в.ср.д. утас: 42, ЮНЕСКО урлагийн ЮНЕСКО БОСДИГ 13 дугаар 13/07
Телеф: 997744, мэйл: zovhogjil@tbb.mn

2019-11-13 № 11/19 Улаанбаатар хот

БАЯНЗҮРХ ДҮРГИЙН ЭРҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХД

Хүсэлт гаргах нь

"Зөв хөгжил, үр дүнт оролцоо" ТББ нь Нээлттэй Нийгэм Форумас зарласан "Хөгжилтэй" хөдөлгөөн 2018 онд Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт хэрэгсэхгүй болсон эрүүгийн хэргийн материалыг хийх төслийг хэрэгжүүлж байгаа юм.

Төслийн зорилго Баянзүрх дүүрэгт Эрүүгийн хэргийн анхан шатны 2018 онд шийдвэрлэгдсэн эрүүгээр хэрэгсэхгүй болсон хэргийн мэдээлэл, судалгааг гарган, хэрэгсэхгүй болсон шалтгаан нь юу байсанг дүн шинжилгээ хийж, санал зөвлөмж дүүртэй бүхий тайлан гаргахад оршино.

Иймд судалгаа дүн шинжилгээний ажлын зорилгоор мэдээлэл авах, хэрэгсэхгүй болсон хэргийн материалыг танилцах боломжоор хангаж хуваах байна. Судалгааны зорилготой ашиглах тул хувь хүн, байгууллагын мэдээллийг заруулахгүй, нууцлалыг хадгалах болно.

Хүндэтгэсэн: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б. МӨНХЖАРГАЛ



ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР
ЭРҮГИЙН ХЭРГИЙН ТӨВ АРХИВ
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Баян толгой 15/1.
Утас: 7011 1997, 32 49 84, И-мэйл: ehta@prokuror.mn


№ 05.23 № 141
Танай _____-ны № _____-т

ТӨР ИРГЭН ТҮНЦЛЭГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТЭРГҮҮН, БАГИЙН АХЛАГЧ Б.АЮУШ ТАНД

Улсын Ерөнхий прокурорын 2011 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 33 тоот тушаалын I хэсэргэлтэн 5-ын 2, 3, 4, 5-д заасны дагуу биений баримтаа бүрдүүлэн эрдэм шинжилгээ судалгааны зориулалтаар ашиглах боломжтой ба дээрх тушаалын III хэсэргэлтэнд дурьдсан тарифаар төлбөр төлжүүлүүр болно.

Иймд нууцын батлалгаа гаргаж, судалгааны зорилго, үр дүн зэргийг тодорхой болгон дээрх шаардлагыг хангасны эцэст тухайн салбар архивт хандаж судалгаа хийж нь зүйтэй.

ЭРХЛЭГЧ, ХУУЛЬ ЦААЗЫН ШАДАР
ЗӨВЛӨХ ЖЧИМГЭЭ



003631


ОРХОН АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР
61033 Түрэн сум, Баян-Өлзийтэй сум, Орхон аймаг
Утас: (976) 7035-8498, E-mail: orkhon@prokuror.mn

№ 09.02 № 111
Танай 09.01.2019-ны № 111-т

ТӨР ИРГЭН ТҮНЦЛЭГ ТББ-ЫН ТЭРГҮҮН Б.АЮУШ ТАНД

Тус аймгийн Прокурорын газарт ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч танилцлаа. Хүсэлтийг хангах боломжгүй болно.

АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА АНХ-ИРЭЭДҮЙ



0601980


ОРХОН АЙМАГ ДАХЬ СҮМ ДУНДЫН ЭРҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ
62021 Орхон аймаг, Баян-Өлзийтэй сум,
Орхон аймагын шүүхийн байр,
Утас: (976) 7030-301,
E-mail: orkhon_19@prokuror.mn

№ 09.11.09 № 31

ТӨР ИРГЭН ТҮНЦЛЭГ ТББ-д

Тус санал асуулгыг ямар зорилгоор юунд ашиглах гэж байгаа нь тодорхойгүй тул судалгааг гарган хүргүүлэх боломжгүй байна.

ЕРӨНХИЙ ШҮҮГч ДАРИУНЦЭЦЭГ



0000511

Тайланг эмхтгэсэн хууль зүйн ухааны доктор,
дэд профессор Б.БАТЗОРИГ

Хянасан тохиолдуулсан ННФ-ын Эрх зүйн
хөтөлбөрийн менежер Б.ХИШИГСАЙХАН



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамьян гүнжийн гудамж-5/1,
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар-14240
Утас: (976-11) 313207,
Факс: (976-11) 324857